

# Бурханы бүрэн хуяг дуулга

Судрууд бидэнд Бурханы “бүрэн хуяг дуулгыг” (Ефес 6:11–18 ба С ба Г 27:15–18-ыг үзнэ үү) өмсөх хэрэгтэй хэмээн заадаг. Биднийг судруудыг судалж, залбирах үед энэ нь биднийг аюулгүй байхад тусалдаг хуяг дуулгыг өмсөж байгаатай адил байдаг.

## АВРАЛЫН ДУУЛГА

Дуулга толгойг хамгаалдаг. Бид Есүсийг дагаж, Түүний биднээр хийлгэхийг хүсэж байгаа зүйлсийг хийснээр оюун санаагаа аюулгүй байлгадаг.



ЗУРАГЧИЙН ИТГЭЛИЙГ  
БРЭНДОН ДОРМАН

## ИТГЭЛИЙН БАМБАЙ

Есүс Христэд итгэх итгэл бол хамгаалалтын бамбайтай адил юм. Бид Есүст итгэж, Түүнтэй адил болохыг хичээснээрээ хүнд хэцүү үедээ ч гэсэн сайн сонголтууд хийж чадна.




## ЗӨВ ШУДАРГЫН БУУЛГА

Буулга нь зүрхийг хамгаалдаг. Бид Бурханыг бүх зурх сэтгэлээрээ хайрлах үедээ Түүний зарлигуудыг дагахыг хичээдэг. Бид зөвийг сонгосон үедээ адислагддаг.



## ҮНЭНИЙ БУСЛУУР

Бүслүүр бол цэргийн биеийг хамгаалахад тусалдаг бүс юм. Юу нь үнэн болохыг мэдэх нь биднийг хамгаалдаг. Сайн мэдээ үнэн бөгөөд сайн мэдээний дагуу амьдрах нь биднийг хүчирхэгжүүлдэг.



## АМАР АМГАЛАНГИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ГУТАЛ

Гутал хөлийг хамгаалдаг. Бид Есүс Христэй хэзээ нэгэн өдөр хамт амьдрах боломжтой болхын тулд Түүний алхам бүрийг дагахыг хичээдэг.



## СҮНСНИЙ ИЛД

Илд нь буруу зүйлтэй тэмцэхэд тусалдаг. Биднийг муу муухай эсвэл хэцүү зүйлтэй тулгарах үед Сүнс бидэнд тусалдаг. Сүнсийг сонсох нь биднийг аюулгүй байхад тусалдаг.



Сүнсээ аюулгүй, аз жаргалтай байлгахын тулд чи өдөр бүр юу хийж болох вэ?